



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/576

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийг захиран зарцуулах журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн V Хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцөд бэлтгэсэн тэжээлийг хадгалах зориулалтаар 40 тонны багтаамжтай 2 ширхэг контейнер худалдан авах, тээвэрлэх, суурилуулах зардлыг хавсралтаар баталж, шаардагдах 26,000,000 (хорин зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

2. Тус ажлыг шуурхай зохион байгуулж, стандартын шаардлага хангасан контейнер худалдан авч, аймгийн Засаг даргад тайлагнахыг “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирал (Б.Одхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



8323010806



КОНТЕЙНЕР ХУДАЛДАН АВАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Арга хэмжээ	Тоо ширхэг	Үнэ	Нийт дүн
1	Контейнэр худалдан авах	2	10,000,000	20,000,000
2	Тээвэрлэлтийн зардал	1	4,000,000	4,000,000
3	Ачиж буулгах, суурилуулалтын зардал	1	2,000,000	2,000,000
	<b>Нийт дүн</b>			<b>26,000,000</b>